

НИЙГМИЙН УХААН ХИЧЭЭЛИЙН 9 ДҮГЭЭР АНГИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ**“А” ХУВИЛБАР****80 МИНУТ****Санамж:** Нийгмийн ухааны шалгалт 40 даалгавар нийт 70 оноотой.

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР: Сонгох хариулт бүхий нэгдүгээр хэсгийн 16 даалгавар байгаа бөгөөд мэдлэг, ойлголтын даалгавар тус бүр 1 оноотой чадварын даалгавар тус бүр 2 оноотой байна.

- Ямар нэгэн мэдээлэл дамжуулахыг зорьж буй тал нь харилцааны үйл явцын аль бүрэлдэхүүн хэсэгт хамаарах вэ? [1 оноо]
А. Мэдээллийг илгээгч В. Хүлээн авагч С. Саад Д. Илэрхийлэх
- Байнгын, тогтвортой харилцааны үйлдлийн явцад нийтлэг адилсал, мэдрэмж бүхий болж бүрэлдэн тогтсон хоёр ба түүнээс дээш хүний нэгдлийг..... гэж ойлгож болно. Цэгийн оронд тохирох хариултыг олно уу. [1 оноо]
А. Анхдагч бүлэг В. Хоёрдогч бүлэг С. Нийгмийн бүлэг Д. Нийтлэг бүлэг
- АНУ-ын эрдэмтэн К.Томас, Р.Киллман нар зөрчилдөөн үүсэхэд түүнийг шийдвэрлэхийн тулд хэр их зүтгэл гаргах эрмэлзэлтэй, асуудлыг зөрчилдөгч талтай хамтран ажиллаад шийдэх сонирхол хэр зэрэг байдаг мөн зөрчилдөөнийг шийдвэрлэх талаар 5 өөр хандлага байдаг гэсэн дүгнэлтэд хүрчээ. Уг 5 хандлагад хамаарагдах ойлголтыг олно уу? Хоёр хариулт сонгоно уу? [2 оноо]
А. Өрсөлдөөн В. Сөргөлдөх С. Хамтран ажиллах Д. Албадлага Е.Солилцоо
- бол хүний бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болдог хувь хүн өөрийгөө хүмүүжүүлэх боломж, арга хэрэгсэл, өөрийнх нь амьдрах орчин юм. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу? [1 оноо]
А. Соёлын хэм хэмжээ В. Соёлын үнэт зүйл С. Соёлын өв Д. Соёлын олон янз байдал
- Манай улс “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-гийн Конвенцод хэдэн онд нэгдэн орсон бэ? /1 оноо/
А. 1972 онд В. 1990 онд С. 2014 онд Д. 2003 онд
- Соёлын өвийг зөв ялган доорх хүснэгтэд байршуулна уу? [2 оноо] Өгөгдөл / 1-хадны бичээс, 2-наадам, 3-гар урлал, 4-хөшөө дурсгал, 5-зан үйл /

Биет өв	a.....
Биет бус өв	b.....

А. a- 1,4 b-2,3,5 В. a- 1,3 b-2,4,5 С. a- 2,4 b-1,3,5 Д. a- 2,5 b-1,3,4

7. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. [3 оноо]

1	Хувь хүн биеэ зөв авч явах шаардлага	А	Хэл
2	Хувь хүнээс өөрийн хэрэгцээг хангахын тулд тухайн зүйлийг хүсэх ба үл хүсэх үнэлгээ	В	Үнэлэмж
3	Хувь хүн бодит байдлыг танин мэдэх болон харилцааны хэрэгсэл болдог соёлын бүрдэл хэсэг	С	Хэм хэмжээ

А. 1c2a3b В. 1b2c3a С. 1c2b3a Д. 1a2c3b

- Хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэхэд бэлэн байгаа төрөл бүрийн мэргэжилтэй ажиллах хүчний тоо нь аль ойлголтод хамаарах вэ? [1 оноо]
А. Хөдөлмөрийн эрэлт В. Хөдөлмөрийн нийлүүлэлт С. Хүний хөдөлмөр Д. хөдөлмөрийн зах зээл
- Хөдөлмөрийн үнэ буюу хүний хөдөлмөрийг ашигласны төлөө түүний тоо, чанарт тохируулан төлж байгаа мөнгөн төлбөрийг цалин гэдэг. Цалинг ба цалин гэж ангилна. [2 оноо]
А..... В.....



10. Хууль тогтоох байгууллага болох Улсын Их Хурлаас батлан гаргаж, нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээ тогтоон, биелэлтийг нь төрийн албадлагын хүчээр хангаж байдаг бичмэл эрх зүйн хэм хэмжээг олно уу? [1 оноо]
A. Тогтоол B. Хуульчилсан акт C. Захирамж D. Хууль
11. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна гэж монгол улсын үндсэн хуулийн хэддүгээр зүйлд заасан байдаг вэ? [1 оноо]
A. 14 дүгээр зүйл B. 17 дугаар зүйл C. 19 дүгээр зүйл D. 20 дугаар зүйл
12. Хүний эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагуудын нэг болох “Шүүхийн байгууллага”-ын шийдвэрлэх асуудлыг олно уу? [2 оноо]
A. Эд зүйл хулгайлах, дээрэмдэх зэрэг гэмт үйлдлийг илрүүлж таслан зогсоох
B. Иргэд хоорондын гэрээний дагуу эд зүйл, өмч хөрөнгийг өмчлөхтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх
C. Захиргааны албан тушаалтан иргэдийн эрхийг зөрчсөн шийдвэр гаргасныг цуцлах
D. Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн боловч төрийн байгууллагууд зохих ёсоор хүний эрхийг хамгаалаагүй тохиолдолд эрхийг нь сэргээн эдлүүлэх
13. Хүүхдийн оролцооны зарчимд хамааралгүй нь аль вэ? [1 оноо]
A. Нээлттэй байх B. Тэгш байх C. Хүртээмжтэй байх D. Ялгаварлахгүй байх
14. Монгол Улсад 1990 онд ардчилсан хувьсгал ялж, анхны ардчилсан сонгуулиар байгуулагдсан Ардын Их Хурал шинэ Үндсэн Хууль (1992)-ийг хэлэлцэж эхэлсэн байдаг. Дараахаас зөв мэдээллийг олно уу? /1 оноо/
A. Үндсэн Хуулийн анхны төслийг «Монгол Улсын Их Хууль» нэртэйгээр 1991 оны 08 сарын 10-наас 10 сарын 01-ний хооронд бүх ард түмнээрээ хэлэлцүүлжээ.
B. Үндсэн Хуулийн анхны төслийг «Монгол Улсын Их Цааз» нэртэйгээр 1991 оны 06 сарын 10-наас 09 сарын 01-ний хооронд бүх ард түмнээрээ хэлэлцүүлжээ.
C. Үндсэн Хуулийн анхны төслийг «Монгол Улсын Их Цааз» нэртэйгээр 1991 оны 02 сарын 10-наас 04 сарын 01-ний хооронд бүх ард түмнээрээ хэлэлцүүлжээ.
D. Үндсэн Хуулийн анхны төслийг «Монгол Улсын Их Хууль» нэртэйгээр 1991 оны 02 сарын 10-наас 09 сарын 01-ний хооронд бүх ард түмнээрээ хэлэлцүүлжээ.
15. Өөрийн орон нутагтаа тулгамдаж байгаа асуудлыг иргэд өөрсдөө эсвэл тэдний төлөөлөл хэлэлцэж шийдвэрлэх нь хэд хэдэн давуу талтай. Үүнд хамааралгүй ойлголтыг олно уу? /1 оноо/
A. Орон нутгийн түвшинд бүх асуудлыг шийдвэрлэдэг болсноор иргэдэд хүрэх төрийн үйлчилгээ ойрхон болно.
B. Орон нутаг бие даасан эрх мэдэлтэй болсноор орон нутгийн хөгжилд нааштай үр нөлөө бий болно.
C. Ардчилал, хүний эрхийг хамгаалах боломж улам бүр бэхэжнэ.
D. Орон нутаг бие даасан эрх мэдэлтэй болсноор хүн амын хэт төвлөрөл бий болно.
16. Төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцох оролцооны олон хэлбэр, арга зам байдаг. Иргэдийн оролцооны хэлбэрийг гүйцээнэ үү? [2 оноо]
A.
B. Төлөөллөөр дамжуулан оролцох
C. Хэлэлцүүлэг, санал асуулгад оролцох
D. Сонирхлын бүлгээр дамжуулж оролцох
E.

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР

Заавар: Дараах даалгаврыг өгөгдсөн зайд цэвэр гаргацтай бичиж гүйцэтгэнэ үү.

17. Тохиолдлыг уншаад зөрчлийг өдөөгч хүчин зүйлс юу болох, мөн зөрчилдөгч талуудыг тодорхойлж, зөрчилдөөнөөс зайлсхийх арга зам юу байсныг бичээрэй. [3 оноо]

Ц ангийн хүүхдүүдтэйгээ нэг өдрийн аялалд явахаар тохирчээ.Ээжийгээ ирэхэд нь “ Би маргааш найзуудтайгаа аялалд явна. Зардлын мөнгө өгөөрэй” гэхэд ээж нь “ Чи хэдэн хоногоор хаачих гээд байгаа юм бэ? “ гэлээ.

- А.Өдөөгч
В. Зөрчидөгч талууд
С. Зайлсхийх хувилбар

18. Эх сурвалжийг уншаад асуултад хариулаарай. [3 оноо]

Эх сурвалж: Хөдөө орон нутагт уламжлалт, угсаатны зүйн эд өлгийн зүйлүүдийг цуглуулдаг ченжүүд айлуудаар явж араг савраас эхлээд аяга, домбо, эмээл хазаар, хуучны гэсэн болгоныг авдаг болов. Манай малчид уламжлалт эд, өлгийн зүйлийг хэрэглэхээ больж байна. Жишээ нь, айргаа хөхүүртээ исгэхээ болилоо, гэрийн бүслүүрээ малынхаа үс хялгасаар хийхээ болилоо.

А. Дээрх эх сурвалжуудад соёлын тухай нийтлэг ямар асуудал байна вэ?

.....
.....

В. Эдгээр асуудал нь ямар шалтгаантай вэ?

.....
.....


С. Шалтгааныг арилгах ямар оролдлогуудыг хийж болох вэ?

.....
.....

19. Хөдөлмөрийн зах зээлийн гурван үүргийг нэрлэнэ үү. [3 оноо]

А.....В.С.....

20. 2017 оны Дэлхийн эрх чөлөөний газрын зургийг харж байна. Энэ зурагт дэлхийн улс орнуудын иргэний, улс төрийн эрх чөлөөний байдлыг 3 түвшинд хуваан харуулжээ. Түвшин бүрд ямар, ямар улс орон хамаарч байгааг нэрлээрэй. [3 оноо]



Чөлөөт ангилал хамаарч байгаа гурван улсыг нэрлэнэ үү?

А. В. С.

ТҮҮХИЙН ХИЧЭЭЛИЙН ДААЛГАВАР

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Хүмүүс неолитийн үеэс байгальд бэлэн байгаа зүйлд найдаж амьдрахаа больж өөрсдөө тарьж ургуулж, өсгөж, үржүүлэх болжээ. Үүнийг ямар аж ахуй гэдэг вэ? (1 оноо)

- А.Түүвэрлэх аж ахуй
В.Үйлдвэрлэх аж ахуй
С.Олзворлох аж ахуй
D. Нүүдлийн мал аж ахуй

2. Эртний Египетчүүдийн тахилгын байгууламжийг юу гэдэг вэ? (1 оноо)

3. Энэхүү байгууламжид гладиаторуудын тулаан, махчин араатнууд хоригдлуудыг хэрхэн идэж байгаа болон мэсчин боолуудын амьтдын эсрэг тулалдаануудыг явуулдаг байв. /1оноо/

А. Ром улс Колизей театр


В.Грек улс Амфитеатр

С. Грек улс Олимп

D. 2 мөрний улс



4. . Он тооллын шугамыг үншиж, асуултад хариулаарай. (2 оноо)



- а) Энэ хугацаанд Монгол нутагт ямар улс оршин тогтнож байсан бэ?
б) Уг улс ямар үгсааны улс вэ?

- a. Сяньби, монгол угсааны улс
b. Жужан, монгол угсааны улс
c. Түрэг, түрэг угсааны улс
d. Уйгур, түрэг угсааны улс

5. Монгол нутагт оршиж байсан эртний улсуудын байгуулагдсан он цагийг зөв тохируулна уу. (3 оноо)

- а. Хүннү 1. IV зуун, I мянган
б. Жужан 2. Одоогоос 1869 жилийн өмнө
в. Сяньби 3. НТӨ III зууны II хагас

6. Тан улсын үеийн Хятад хүмүүсийн баримтлан дагадаг сургаал аль вэ? (1 оноо)

- A. Библийн судар
B. Коран судар
C. Күнзийн сургаал
D. Их бага хөлгөний судар

7. Дундад зууны Японы Яматогийн улсыг юу гэж нэрлэдэг байсан бэ? (1 оноо)

- A. Ниппон B. Тэнно C. Харакири D. Шинто

8. Чингис хааны дэлхийн түүхэнд гүйцэтгэсэн үүргийг ялгана уу. (2 оноо)


1. Их Монгол улсыг байгуулсан. 2. Өрнө Дорнын хооронд худалдаа соёлын харилцаа хөгжив.
3. Мянгатын системийг бий болгов. 4. Евразийг дамнасан газар нутагт нэгдсэн дэг журам тогтоосон.
A. 1, 2 B. 2, 3 C. 2, 4 D. 1, 3

9. Татар хүний бие бялдар өндөр бус, хамгийн өндөр нь таван тохой хоёр, гурван ямхаас давахгүй бас тарган биш, нүүр өргөн бөгөөд хавтгай, хацрын яс товгор, нүд давхраагүй. Үс сахал бага. гэж бичжээ. (Нэг тохой 35 см орчим, Ямх-3,2 см орчим)

Монгол хүний хамгийн өндөр хэдэн метр болохыг тооцоолно уу. (2 оноо)

- A. 175,6 m B. 180m C. 184,6 m D. 190 m

10. Монголын эзэнт улсуудын талаарх газарзүйн зургийг анхааралтай ажиглан асуултад хариулна уу.
(3 оноо)



Эзэнт улсуудын нэр	Хэн, хэзээ байгуулсан
1.....	
2.....	
3.....	
4.Ил хаант улс	1256 Хүлэгү

11. 1492 оны 10-р сарын 12 нд Төв Америкийн арлуудад хүрч, Америк тивийг нээсэн хүн хэн бэ?
(1 оноо)

- А. Фернан Магеллан
В. Васко да Гама
С. Христофер Колумб
D. Тосканелл

12. Доорх зурган дээрх бүтээлийг хэн нээсэн бэ? (1 оноо)

- А. Уилья Гарвей
В. Ж.Кардоно
С. Николис Коперник
D. Леонардо Да Винчи



13. Британийн байгаль судлаач Чарльз Дарвины дэвшүүлсэн “Хувьслын онол”-ын гол үзэл санаа юу байв? (2 оноо)

- А. Дэлхий бол ертөнцийн төв
В. Дэлхий бол хавтгай
С. Хүн, амьтныг бурхан бүтээсэн
D. Хүн, амьтныг бурхан бүтээсэн гэх номлолыг үгүйсгэсэн

14. 1900 он гэхэд Франц улс Африкийн 50,5 сая хүн амтай /нийт Африкчуудын 32,3% газар нутгийн 42,1% эзэлж байжээ. Уг үйл явдал хэддүгээр зуунд, буюу одоогоос хэдэн жилийн өмнө болсон бэ?
(2 оноо)

- А. XIX зуунд, 125 жилийн өмнө
В. XX зуунд, 125 жилийн өмнө
С. XIX зуунд, 3925 жилийн өмнө
D. XX зуунд, 125 жилийн өмнө

15. Сурвалжийн мэдээг анхааралтай уншаад асуултад хариулна уу. /3 оноо/

1755-1758 онд гарсан ардын том бослогыг зохион байгуулж удирдах ажлыг Зүүнгарын Амарсанаа, Халхын Засагт хан аймгийн туслах жанжин, Хотгойдын шадар ван Чингүнжав нар гүйцэтгэсэн

Дорнод аймгийн Боловсролын газар

2024-2025 оны хичээлийн жил

бөгөөд Хорчин ван эфү Сэвдэнбалжир тэргүүтэй Өвөр монголын хэсэг ноёд бослогын бэлтгэл ажилд идэвхтэй оролцон, Амарсанаа, Чингүнжав нартай нягт холбоотой ажиллаж байжээ. Ингэж Баруун Монгол, Халх Монгол болон Өвөр Монголын нөлөө бүхий том ноёд тусгаар тогтнолын тэмцлийг бэлтгэж зохион байгуулах, удирдан явуулахад идэвхийлэн оролцох болсон нь манжийн ноёрхлыг монголчууд хичнээн дургүйцэн жигшиж, эх орныхоо тусгаар тогтнолын үйл хэргийг хичнээн их эрхэмлэн үзэж байсныг тодорхой харуулж байгаа юм. "... Чингүнжав оргосон урианхайг нэхэж Хөх усны зэрэг газарт хүрээд цаашаа давшиж орсонгүй дур мэдэн цэргээ авч хойш буцан айлтгасан нь: олон Халхчууд гаслалдан хэлэлцэнэ. Бас Амарсанааг барихад дэмий олныг зовоож улсын цалингашиггүй сүйтгэнэ."

а. Халх Монголд тусгаар тогтнолын зэвсэгт бослогыг хэн эхлүүлсэн бэ?

б. Өвөр Монголд бослогыг удирдан зохион байгуулах үүрэг хүлээсэн язгууртан хэн бэ?

с. Чингүнжавыг гэр бүлийн хамтаар баривчлан Бээжинд хүргэн тамлан цаазлах болсон шалтгааныг тайлбарлана уу.

д. Бослого амжилт олоогүй шалтгааныг бичнэ үү.

е. Энэхүү 1755-1758 оны зэвсэгт бослогын түүхэн ач холбогдлыг тайлбарлана уу

Ф. Түүхэн сургамжийг бичнэ үү

16. "1911 оны 12-р сарын 29-ний өдрийн яг ёслол болсон цаг мөчид, Монголын өнцөг булан бүрд хүмүүс Хүрээний зүг хандаж, нэгэн зэрэг сөгдөн мөргөж, зул, хүж өргөн баясжээ"

Дээрх түүхэн үйл явдал юуг илэрхийлж байна вэ? (1 оноо)

A. Ёс заншил, өв уламжлалаа хүндэтгэх үзэл санааг

B. Эрх чөлөө, тусгаар тогтнолын үнэ цэн

C. Өвөг дээдсээ хүндэтгэх ёсыг бэхжүүлэх үйл хэрэг

D. Шашин шүтлэг, өв соёлоо хүндэтгэх үйл явдал

17. Цэгийн оронд тохирохыг сонгоно уу. (1 оноо)

Зөвлөлтийн удирдагчид Монголд буруу бодлого тулган хэрэгжүүлснээ ухаарч, 1932 оны зунаас хэрэгжүүлсэн юм.

A. Шинэ засгийн бодлого


B. Шинэ эргэлтийн бодлого

C. Шинэ сэргэлтийн бодлого

D. Шинэ зууны бодлого

18. Графикийг ажиглан зөв хариултыг сонгоно уу.

(2 оноо)




Бүдүүвч 3.5. Эрүүлийг хамгаалахад зориулсан төсөв (мян.төг)

A. Жил ирэх тусам санхүүжилт буурсан

B. Хүн амын тоо буурсан

D.Манай улс эрүүл мэнддээ анхаардаггүй байсан

19. Цэгийн оронд тохирох үйл явдлыг нөхнө үү. (2 оноо)



-
- A. Солонгосын дайн, Афганистаны дайн B. Вьетнамын дайн, Афганистаны дайн
C. Солонгосын дайн, Вьетнамын дайн D. Дэлхийн II дайн, Төвөдийн бослого

20. 1990 онд “Монголын нууц товчоо” зохиогдсоны 750 жилийн ойг тэмдэглэсэн. “Монголын нууц товчоо” хэдэн онд зохиогдсон болон хэддүгээр зуунд хамаарахыг тооцоолж бодно уу. (2 оноо)

- A. 1206 он-XI зуун B. 1189 он-XII зуун
C. 1227 он- XII зуун D. 1240 он-XIII зуун

_____оОо_____

НИЙГМИЙН УХААН ХИЧЭЭЛИЙН 9 ДҮГЭЭР АНГИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ**“В” ХУВИЛБАР****80 МИНУТ****Санамж:** Нийгмийн ухааны шалгалт 40 даалгавар нийт 70 оноотой.

1. Илгээгчийн дамжуулахыг хүссэн мэдээлэл хүлээн авагч талд хүрч чадсан уу? гэдгийг эргэн нягтлах үйл явц аль нь вэ? [1 оноо]

A. Мэдээллийг илгээгч B. Хүлээн авагч C. Эргэх холбоо D. Илэрхийлэх

2.нь нийтлэг зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө албан ёсны, бичигдмэл хэм хэмжээгээр гишүүдийн харилцаа зохицуулагддаг. Тухайлбал сургууль, цэцэрлэг, эмнэлэг гэх мэт бүх төрлийн байгууллага багтана. Цэгийн оронд тохирох хариултыг олно уу. [1 оноо]

A. Анхдагч бүлэг B. Хоёрдогч бүлэг C. Нийгмийн бүлэг D. Нийтлэг бүлэг

3. АНУ-ын эрдэмтэн К.Томас, Р.Киллман нар зөрчилдөөн үүсэхэд түүнийг шийдвэрлэхийн тулд хэр их зүтгэл гаргах эрмэлзэлтэй, асуудлыг зөрчилдөгч талтай хамтран ажиллаад шийдэх сонирхол хэр зэрэг байдаг мөн зөрчилдөөнийг шийдвэрлэх талаар 5 өөр хандлага байдаг гэсэн дүгнэлтэд хүрчээ. Уг 5 хандлагад хамаарагдах ойлголтыг олно уу. Хоёр хариулт сонгоно уу. [2 оноо]

A. Буулт хийх B. Албадлага C. Өрсөлдөөн D. Зайлсхийх E. Солилцоо

4. Хувь хүний болон нийгмийн бүлгүүдийн соёлын сонголтын ялгаатай байдлыг илэрхийлэг ойлголт аль нь вэ? /1оноо/

A. Соёлын хэм хэмжээ B. Соёлын үнэт зүйл C. Соёлын өв D. Соёлын олон янз байдал

5. Байгалийн болон соёлын өвийг хамгаалж, таниулан сурталчлах, хойч үедээ үлдээх зорилгоор дээрх өвийг хамгаалах тухай Конвенцыг хэдэн оноос батлан хэрэгжүүлж эхэлсэн бэ? /1оноо/

A. 1972 онд B. 1990 онд C. 2014 онд D. 2003 онд

6. Соёлын өвийг зөв ялган доорх хүснэгтэд байршуулна уу. [2 оноо]

Өгөгдөл / 1-Хөгжим, 2-наадам, 3-археологийн дурсгал, 4-үлгэр домог, 5-булш хиргисүүр /

Биет өв	a.....
Биет бус өв	b.....

A. a- 1,4 b-2,3,5 B. a- 1,3 b-2,4,5 C. a-3, 5 b-1,2,4 D. a- 2,5 b-1,3,4

7. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. [3 оноо]

1	Түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгалт зүйлс	A	Соёлын өв
2	Түүхэн тодорхой цаг үеийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл,урлаг, шинжлэх ухааны ач холбогдол бүхий зүйлс	B	Соёлын биет өв
3	Хамт олон бүлэг хүмүүс, зарим тохиолдолд хувь хүмүүс соёлын өвийнхөө бүрэлдэхүүн гэж хүлээн зөвшөөрсөн заншил, зан үйл, уламжлалт мэдлэг, арга барил	C	Соёлын биет бус өв

A. 1c2a3b B. 1b2c3a C. 1a2c3b D. 1b2a3c

8. Цалингаар баталгаажсан ажиллах хүчний хэрэгцээ, шаардлага нь аль ойлголтод хамаарах вэ?/1оноо/

A. Хөдөлмөрийн эрэлт B. Хөдөлмөрийн нийлүүлэлт C. Хүний хөдөлмөр D. Хөдөлмөрийн зах зээл

9. Хөдөлмөрийн үнэ буюу хүний хөдөлмөрийг ашигласны төлөө түүний тоо, чанарт тохируулан төлж байгаа мөнгөн төлбөрийг цалин гэдэг. Цалинг ба цалин гэж ангилна. [2 оноо]

A..... B.....

10. Нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн харилцааг зохицуулахаар захиргааны байгууллага, албан тушаалтнаас бичгээр гаргасан захирамжилсан шийдвэрийг олно уу. [1 оноо]
A. Тогтоол B. Хуульчилсан акт C. Захирамж D. Хууль
11. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж монгол улсын үндсэн хуулийн хэддүгээр зүйлд заасан байдаг вэ? [1 оноо]
A.14 дүгээр зүйл B.17 дугаар зүйл C.19 дүгээр зүйл D.20 дугаар зүйл
12. Хүний эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагуудын нэг болох “Хүний эрхийн үндэсний комиссын” шийдвэрлэх асуудлыг олно уу. [2 оноо]
A. Эд зүйл хулгайлах, дээрэмдэх зэрэг гэмт үйлдлийг илрүүлж таслан зогсоох
B. Иргэд хоорондын гэрээний дагуу эд зүйл, өмч хөрөнгийг өмчлөхтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх
C. Захиргааны албан тушаалтан иргэдийн эрхийг зөрчсөн шийдвэр гаргасныг цуцлах
D. Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн боловч төрийн байгууллагууд зохих ёсоор хүний эрхийг хамгаалаагүй тохиолдолд эрхийг нь сэргээн эдлүүлэх
13. Хүүхдийн оролцооны зарчимд хамааралгүй нь аль вэ? [1 оноо]
A. Шударга байх B. Тэгш байх C. Нээлттэй байх D. Ялгаварлахгүй байх
14. Монгол Улсад 1990 онд ардчилсан хувьсгал ялж, анхны ардчилсан сонгуулиар байгуулагдсан Ардын Их Хурал шинэ Үндсэн Хууль (1992)-ийг хэлэлцэж эхэлсэн байдаг. Дараахаас зөв мэдээллийг олно уу. [1 оноо]
A. Төслийг нийт 7000 гаруй байгууллагад хэлэлцэж, түүнд 900 000 гаруй хүн оролцож, давхардсан тоогоор 220 000 -аад санал иржээ.
B. Төслийг нийт 3400 гаруй байгууллагад хэлэлцэж, түүнд 800 000 гаруй хүн оролцож, давхардсан тоогоор 120 000 -аад санал иржээ.
C. Төслийг нийт 7300 гаруй байгууллагад хэлэлцэж, түүнд 700 000 гаруй хүн оролцож, давхардсан тоогоор 320 000 -аад санал иржээ.
D. Төслийг нийт 7000 гаруй байгууллагад хэлэлцэж, түүнд 730 000 гаруй хүн оролцож, давхардсан тоогоор 100 000 -аад санал иржээ.
15. Өөрийн орон нутагтаа тулгамдаж байгаа асуудлыг иргэд өөрсдөө эсвэл тэдний төлөөлөл хэлэлцэж шийдвэрлэх нь хэд хэдэн давуу талтай. Үүнд хамааралгүй ойлголтыг олно уу. [1 оноо]
A. Орон нутгийн түвшинд бүх асуудлыг шийдвэрлэдэг болсноор иргэдэд хүрэх төрийн үйлчилгээ ойрхон болно.
B. Орон нутаг бие даасан эрх мэдэлтэй болсноор орон нутгийн хөгжилд нааштай үр нөлөө бий болно.
C. Орон нутаг бие даасан эрх мэдэлтэй болсноор хүн амын дунд ядуурал нэмэгдэнэ.
D. Ардчилал, хүний эрхийг хамгаалах боломж улам бүр бэхэжнэ.
16. Төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцох оролцооны олон хэлбэр, арга зам байдаг. Иргэдийн оролцооны хэлбэрийг гүйцээнэ үү. [2 оноо]
A. Улс төрийн сонгуульд оролцож санал өгөх
B.
C. Хэлэлцүүлэг, санал асуулгад оролцох
D.
E. Нийгмийн сүлжээ хэвлэл мэдээллийн хэргсэл ашиглах



ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР:

Заавар: Дараах даалгаврыг өгөдсөн зайд цэвэр гаргацтай бичиж гүйцэтгэнэ үү

17. Тохиолдлыг уншаад зөрчлийг өдөөгч хүчин зүйлс юу болох, мөн зөрчилдөгч талуудыг тодорхойлж, зөрчилдөөнөөс зайлсхийх арга зам юу байсныг бичээрэй. [3 оноо]

Т найзтайгаа хамт нэг автобусаар өглөө эрт хичээлдээ явахаар тохирсон боловч найз нь хоёр ч удаа цагтаа ирэлгүй автобуснаасаа хоцорчээ. Энэ удаа найзыгаа оройтож ирэхэд Т “Чи ямар сонин юм бэ, би чамтай дахиж хамт явахгүй” гэв.

- А. Өдөөгч
В. Зөрчидөгч талууд
С. Зайлсхийх хувилбар

18. Эх сурвалжийг уншаад асуултад хариулаарай. [3 оноо]

Эх сурвалж: “Чанартай, чансаатай, жинхэнэ сонгодог бүхэн ард олонд хүртээмжгүй, үнэ зардал ихтэй, ойлгомжгүй болж байна. Хямд, чанаргүй, үнэ цэнэгүй, агуулгагүй бүхнээр өөрийгөө дүүргэсэн хүмүүн өнөөдөр араатан авиртай болж, гэмт хэргийн эзэн болсоор байна. Хүний ухамсрыг соёлын аргаар энэ мэтчилэн угаах нь хүний мөс, нийгмийн ёс, үндэстний яс эвдрэх нөхцөлийг бүрдүүлсээр байна”.

А. Дээрх эх сурвалжуудад соёлын тухай нийтлэг ямар асуудал байна вэ?

.....

В. Эдгээр асуудал нь ямар шалтгаантай вэ?

.....


С. Шалтгааныг арилгах ямар оролдлогуудыг хийж болох вэ?

.....

19. Ажилгүйдлийг бууруулах гурван арга замыг нэрлэнэ үү. /3 оноо/

А.....В.С.....

20. 2017 оны Дэлхийн эрх чөлөөний газрын зургийг харж байна. Энэ зурагт дэлхийн улс орнуудын иргэний, улс төрийн эрх чөлөөний байдлыг 3 түвшинд хуваан харуулжээ. Түвшин бүрд ямар, ямар улс орон хамаарч байгааг нэрлээрэй. [3 оноо]



Чөлөөт бус ангилал хамаарч байгаа гурван улсыг нэрлэнэ үү.

А. В. С.

ТҮҮХИЙН ХИЧЭЭЛИЙН ДААЛГАВАР

1. Хүн төрөлхтөн олзворлох, түүвэрлэх аж ахуйн дараа ямар аж ахуйд шилжсэн бэ? (1 оноо)

- А. Мал аж ахуй, газар тариалан
В. Ан агнуур, загасчлал
С. Гар урлал, худалдаа
D. Ан агнуур, гар урлал

2. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу. (1 оноо)

Вавилончууд дэлхийн хамгийн анхны бүтээсэн юм.

- А. зиггурат
В. пирамид
С. Папирус
D. бичмэл хууль

2024-2025 оны хичээлийн жил

3. Эртний Грек улсын түүхэнд холбогдох вааран дээрх дүрслэл ямар утга санаа илэрхийлдэг вэ? (2 оноо)

A. Бүжиглэж буй хүмүүс

B. Олимпийн наадам

C. Дайн байлдаан

D. Дуулж буй хүмүүс




4. Он тооллын шугамыг уншиж, асуултад хариулаарай. (2 оноо)

(2 оноо)

НТӨ

ХМ

НТ



а) Энэ хугацаанд Монгол нутагт ямар улс оршин тогтнож байсан бэ?

б) Уг улс ямар угсааны улс вэ?

a. Жужан, монгол угсааны улс

b. Сяньби, монгол угсааны улс

c. Түрэг, түрэг угсааны улс

d. Уйгур, түрэг угсааны улс

5. Монгол нутагт оршиж байсан эртний улсуудын байгуулагдсан он цагийг зөв тохируулна уу. (3 оноо)

a. Хүннү

1. IV зуун, I мянган

b. Жужан

2. II зууны II хагас

c. Сяньби

3. Одоогоос 2234 жилийн өмнө байгуулагдсан

a3b1c2

6. Дундад зууны Энэтхэгчүүдийн шүтдэг Брахма, Вишну, Шива бурхад аль шашны бурхад вэ? (1 оноо)

A. Загалмайн шашин

B. Лалын шашин

C. Даогийн шашин

D. Индус шашин

7. Дундад зууны Японд Яматогийн хаад Хятадын Сүй улсаас ямар цолыг авч хэрэглэх болсон бэ? (1 оноо)

A. Ниппон

B. Тэнно

C. Харакири

D. Шинто

8. Чингис хааны дэлхийн түүхэнд гүйцэтгэсэн үүргийг ялгана уу. (2 оноо)

1. Их Монгол улсыг байгуулсан.

2. Өрнө Дорнын хооронд худалдаа соёлын харилцаа хөгжив

3. Мянгатын системийг бий болгов

4. Евразийг дамнасан газар нутагт нэгдсэн дэг журам

тогтоосон

A. 1, 2

B. 2, 3

C. 2, 4

D. 1, 3

9. Чингисийн чулууны бичигт “Чингис хаан Сартуул иргэнийг дагуулж бууж хамаг Монгол улсын ноёд Буха Сочигайд хурсанд Есүнгэ ондutrун гурван зуун гучин таван алдаст ондутлугаа” гэж бичжээ. (1 алд-1.6 метр).

Есүнгэ мэргэний оносон 335 алд хэдэн метр болохыг тооцоолно уу.

(2 оноо)

A. 53.6 м

B. 536м

C. 335 м

D. 5.36 км

10. Монголын эзэнт улсуудын талаарх газарзүйн зургийг анхааралтай ажиглан асуултад хариулна уу. (3 оноо)



Эзэнт улсуудын нэр	Хэн, хэзээ байгуулсан
1.....	1242 онд Зүчийн хүү Бат
2.....	
3.....	
4.Ил хаант улс	

11. Ногоон хошууны арал, Рео-де-Жанейрогийн булан, Номхон далай хүрч улмаар дэлхийг тойрсон далайчин хэн бэ? (1 оноо)

- A. Фернан Магеллан
B. Васко да Гама
C. Христофер Колумб
D. Тосканелл

12. Доорх зурган дээрх бүтээлийг хэн нээсэн бэ? (1 оноо)

- A. Чарлыз Дарвин
B. Томас Эдисон
C. Николис Коперник
D. Леонардо Да Винчи



Гэрлийн чийдэн

13. АНУ-д 1876 онд Александр Грэхэм Белл Телефон утсыг нээсэн нь ямар ач холбогдолтой вэ? (2 оноо)

- A. Харилцаа холбооны шинэ салбар болон хөгжив. B. Хүн, амьтныг бурхан бүтээсэн гэх номлолыг үгүйсгэсэн C. Барилга, цэргийн салбарт ашиглажээ. D. Гурван хүний ажил гүйцэтгэдэг болов

14. 1901 он гэхэд Англи улс Африкийн 79,6 (хүн амын 49,4%) сая хүн бүхий 37,7% газар нутгийг эзэмших болжээ. Уг үйл явдал хэддүгээр зуунд, буюу одоогоос хэдэн жилийн өмнө болсон бэ? (2 оноо)

- A. XX зуунд, 124 жилийн өмнө B. XXI зуунд, 124 жилийн өмнө
C. XIX зуунд, 3926 жилийн өмнө D. XX зуунд, 3926 жилийн өмнө

15. Сурвалжийн мэдээг анхааралтай уншаад асуултад хариулна уу. /3 оноо/

1755-1758 онд гарсан ардын том бослогыг зохион байгуулж удирдах ажлыг Зүүнгарын Амарсанаа, Халхын Засагт хан аймгийн туслах жанжин, Хотгойдын шадар ван Чингүнжав нар гүйцэтгэсэн бөгөөд Хорчин ван эфү Сэвдэнбалжир тэргүүтэй Өвөр монголын хэсэг ноёд бослогын бэлтгэл ажилд идэвхтэй оролцон, Амарсанаа, Чингүнжав нартай нягт холбоотой ажиллаж байжээ. Ингэж Баруун Монгол, Халх Монгол болон Өвөр Монголын нөлөө бүхий том ноёд тусгаар тогтнолын тэмцлийг бэлтгэж зохион байгуулах, удирдан явуулахад идэвхийлэн оролцох болсон нь манжийн

Дорнод аймгийн Боловсролын газар

2024-2025 оны хичээлийн жил

ноёрхлыг монголчууд хичнээн дургүйцэн жигшиж, эх орныхоо тусгаар тогтнолын үйл хэргийг хичнээн их эрхэмлэн үзэж байсныг тодорхой харуулж байгаа юм. "... Чингүнжав оргосон урианхайг нэхэж Хөх усны зэрэг газарт хүрээд цаашаа давшиж орсонгүй дур мэдэн цэргээ авч хойш буцан айлтгасан нь: олон Халхчууд гаслалдан хэлэлцэнэ. Бас Амарсанааг барихад дэмий олныг зовоож улсын цалингашиггүй сүйтгэнэ."

а. Баруун Монголд тусгаар тогтнолын зэвсэгт бослогыг хэн эхлүүлсэн бэ?

б. Өвөр Монголд бослогыг удирдан зохион байгуулах үүрэг хүлээсэн язгууртан хэн бэ?

в. Чингүнжавыг гэр бүлийн хамтаар баривчлан Бээжинд хүргэн тамлан цаазлах болсон шалтгааныг тайлбарлана уу.

д. Бослого амжилт олоогүй шалтгааныг бичнэ үү.

е. Энэхүү 1755-1758 оны зэвсэгт бослогын түүхэн ач холбогдлыг тайлбарлана уу

ф. Түүхэн сургамжийг бичнэ үү

16. "1911 оны 12-р сарын 29-ний өдрийн яг ёслол болсон цаг мөчид, Монголын өнцөг булан бүрд хүмүүс Хүрээний зүг хандаж, нэгэн зэрэг сөгдөн мөргөж, зул, хүж өргөн баясжээ. Үүнийг үзсэн гадаадынхан олон Монголчуудын нүд урьд өмнө хэзээ ч ингэж гэрэлтэж байсныг хараагүй" хэмээн бичсэн байдаг.


Дээрх түүхэн үйл явдал ямар утга санаа илэрхийлж байна вэ? (1 оноо)

- A. Өв уламжлал, шашнаа дээдлэх зан үйл, үйл хэрэг
B. Ёс заншил, өв уламжлалаа хүндэтгэх ёсыг бэхжүүлэх үйл хэрэг
C. Шашин шүтлэг, өв соёлоо хүндэтгэх үйл хэрэг
D. Үндэсний сэргэн мандалтын бодит үр дүн, үйл хэрэг

17. 1932 оны зун эхэлсэн эдийн засаг, аж ахуй, соёлын салбарт богинохон хугацаанд томоохон ахиц дэвшил авчирсан бодлогыг юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)

- A. Шинэ засгийн бодлого
B. Шинэ эргэлтийн бодлого
C. Шинэ сэргэлтийн бодлого
D. Шинэ зууны бодлого

18. Графикийг ажиглан зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)




Бүдүүвч 3.4. Нэг эмчид ногдох өвчтөний тоо

- A. Жил ирэх тусам эмч нарын тоо буурсан байна.
B. Хүн амын тоо буурсан үзүүлэлт гарсан байна.
C. Монгол улсын эрүүл мэндийн хөгжлийг харуулсан байна.
D. Манай улсын хүн ам өссөн байна.

19. Цэгийн оронд тохирох үйл явдлыг нөхнө үү.

(1 оноо)



A. Солонгосын дайн, Афганистаны дайн B. Вьетнамын дайн, Афганистаны дайн

C. Солонгосын дайн, Вьетнамын дайн D. Дэлхийн II дайн, Төвөдийн бослого

20. “Чингис хааны хааны мэндэлсний” 840 жилийн ойг тэмдэглэсэн. нь хэдэн онд болон хэддүгээр зуунд хамаарахыг тооцоолж бодно уу. (2 оноо)

A. 1962 он-XIX зуун

B. 1162 он-XII зуун

C. 2002 он- XXI зуун

D. 2012 он-XXI зуун

_____оОо_____